

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

/2012 оны эхний хагас жилийн байдлаар/

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 5.7 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 82.3 хувиар биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.7 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 3.9 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 7.1 хувиар доогуур гүйцэтгэлтэй байна.

Эхний хагас жилд 425.6 сая төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт хийгдсний дотор 258.6 сая төгрөг нь төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын салбарт, 87 сая төгрөг нь нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээнд, 40 сая төгрөг нь боловсролын болон эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт тус тус оржээ.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 38.4 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 3.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 23.9 тэрбум төгрөг хүрсэн нь оны эхнээс 7.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 83.3 хувь болох 752.2 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.3 хувь болох 753.0 мянган төл бойжиж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 36.5 мянган толгойгоор дээгүүр байна.

Оны эхний малын 0.6 хувь болох 12.8 мянган том мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 99.4 хувьтай байна.

Хорогдлын 51.2 хувийг ямаа, 42.8 хувийг хонь эзлэж байна. Түмэнцогт, Мөнххаан, Наран сумдад оны эхний малын 4.0-0.6 хувь нь хорогдоод байгаа нь бусад сумдаасаа өндөр байна.

Тариалалт: 64.5 га-д төмс, 23.6 га-д хүнсний ногоо тариалсан нь урьд оны мөн үеэс төмс 1.3 хувиар дээгүүр, хүнсний ногоо 21.7 хувиар доогуур гүйцэтгэлтэй байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 16.8 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 3.3 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна. Оны үнээр 61.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 6.3 тэрбум төгрөгөөр дээгүүр байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, ул боов, нүүрс, цайрийн баяжмалын үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр гүйцэтгэлтэй байна. Шинээр тарагны үйлдвэрлэлт нэмэгдэж орсон байна.

V. БАРИЛГА, ТЭЭВЭР, ХОЛБОО: Барилга: Барилгын 15 байгууллага улсын төсвийн хөрөнгөөр 6644.1 сая төгрөгийн, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 77.6 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь урьд оны мөн үеэс дээгүүр байна.

Тээвэр: Тээвэр бүхий байгууллагууд 24.5 сая.тн.км-ийн ачаа эргэлт, 12.8 сая.хүн.км-ийн зорчигч эргэлт хийж, 3.5 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Холбоо: Холбоо ашиглалтын орлого 246.7 сая төгрөг байгаагийн дотор 100.9 сая төгрөг нь хүн амаас орсон байна. Телефон цэгийн тоо 1387 болж урьд оны мөн үеэс 12.8 хувиар буурсан байна.

VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 6-р сард өмнөх 2011 оны жилийн эцсийнхээс 6.2 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 12 хувь, тээврийн бүлгийн үнэ 11.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 17.6 хувь, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 1.3-4.9 хувиар тус тус өссөн байна. Боловсролын үйлчилгээ, холбооны үнэ, тариф жилийн эцэст байсан хэмжээндээ тогтвортой байна.

VII. СОЁЛ, БОЛОВСРОЛ: Соёл: ХЖТеатр 3.4 сая төгрөгийн орлоготой ажилласан. Энэ нь 13 суманд бригад явж тоглолт хийсэн ч одоог хүртэл билетийн орлого орж ирээгүй байна.

Музей: 1.8 мянган үзмэрээр 0.8 мянган хүнд үйлчилж, 678.7 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Нийтийн номын сан: 14.3 мянган уншигчдад 43.1 мянган номоор үйлчилж 130 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ.

Боловсрол: ЕБС-ийн 2011-2012 оны хичээлийн жилд 3208 хүүхэд төгссөний дотор 662 хүүхэд бүрэн дунд боловсролыг, 1491 хүүхэд суурь боловсролыг, 1079 хүүхэд бага боловсрол эзэмшлээ.

VIII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 3.6 тэрбум төгрөг болж төлөвлөгөөгөө 13.5 хувиар давж биелэв. Сайн дурын даатгуулагчид 81.3 сая төгрөгний шимтгэл оруулсан байна. 6138 өндөр настанд 5.7 тэрбум төгрөгийн тэтгэвэрийг бүрэн олгосон байна. Нийгмийн халамжийн сангаас 0.9 тэрбум төгрөгийг 4.2 мянган иргэнд, улсын төсвөөс 17.2 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 61.7 мянган иргэнд олгосоны дотор хүний хөгжил сангаас 16.2 тэрбум төгрөгийг 54.6 мянган иргэнд тус тус олгосон байна.

IX. ЭРҮҮЛ МЭНД: Эхний 6 сард 630 эх амаржиж, 630 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр байна.

Халдварт өвчнөөр 352 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 71-ээр олон байгаа бөгөөд гепатит, тэмбүү, салхинцэцэг, мөөгөнцөр, трихоминиаз зэрэг өвчлөлүүд өссөн байна.

X. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 908 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 202 хүнээр буурсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 73.7 хувь нь 16-34 насны залуучууд байна. Боловсролын хувьд 19.7 хувь нь дээд, 2.5 хувь нь тусгай дунд, 42.2 хувь нь бүрэн дунд, 7 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

894 хүн шинээр бүртгүүлж, 726 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 342 хүн ажиллаж байна.

XI. ГЭМТ ХЭРЭГ: Эхний хагас жилийн байдлаар 117 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 13-аар дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 18 хүн нас барж, 39 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 149.8 сая төгрөгийн хохирол учирсны 147.8 саяыг нь нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 95 хүн холбогдон сэжиглэгдсэний 27.3 хувь нь согтуугаар, 9.5 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 1900 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 507 хүнээр олон байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 83 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

XII.МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ ТӨСӨЛ: Төслийн хүрээнд 13 суманд 4 даатгалын компанийн 86 төлөөлөгч ажиллаж байна.


XIII. ДААТГАЛ: Даатгалын байгууллагуудын хураамжийн орлогоор 218265.3 сая төгрөг орж, төлөвлөгөө нь 135.2 хувиар өссөн байна. 226 хүнд 9.5 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Үүнээс авто тээврийн хэрэгсэлд 768.0 мянга, гэнэтийн осолд 4.0 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 1.9 сая, хүүхдийн гэнэтийн осолд 185.5 мянган төгрөгийг тус тус олгожээ.

XIV. ТӨСӨЛ: ХЭДСАН: Аймгийн хэмжээгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 238 иргэнд 584.3 сая төгрөгийн зээл олгож, 594 ажлын байрыг бий болгосон байна.

ТА-2 төсөл: Тогтвортой амжиргаа II төслийн хүрээнд аймгийн хэмжээгээр 177.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэний дотор тохижуулалтанд 26.7 сая, худаг сэргээн засварлахад 27.6 сая, бусад үйл ажиллагаанд 122.9 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Хоршоологчдыг дэмжих жилийн хүрээнд: Улсын хэмжээнд 103 хоршоог жишиг хоршоо болгон шалгаруулсан. Манай аймгаас үүнд 4 хоршоо шалгарч тус бүр 17.8 сая төгрөгний дэмжлэг авахаар болсон. Үүнд: Баяндэлгэр сумын “Эх орны төлөө”, Мөнххаан сумын “Хайрхан чулуун тал”, Сүхбаатар сумын “Номтын энгэр”, Баруун-Урт сумын “Мөнгөн саам” зэрэг хоршоод шалгарсан байна. Улсаас олгох тус мөнгөний 8.7 сая төгрөгийг жилийн 6.0 хувийн хүүтэй эргэн төлөх, үлдсэн 9.1 сая төгрөгийг эргэн төлөгдөхгүй байхаар шууд олгоно.

XV. ГАЗАР ӨМЧЛӨЛ: Оны эхний 6 сард 837 иргэн газар өмчилж авах өргөдөл гаргаж, 904 иргэний өргөдлийг шийдвэрлэж, 75.95 га газрыг өмчлүүлж, өссөн дүнгээр нийтдээ 6186 иргэн өргөдөл гаргаж, 6036 иргэний өргөдлийг шийдвэрлэж, 569.58 га газрыг өмчлүүлээд байна.



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС